Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Салбарын хяналтын газрын ахлах мэргэжилтэн, Гунгаа Сүнжидмаа

2024 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Иргэний сурч боловсрох эрх, тэгш боломж, чанартай боловсрол эзэмших, эрүүл, аюулгүй орчин нөхцөлийг хангуулах, салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн баталсан нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог бэхжүүлэх | | | | | | | |
| 1 | Эрсдэлийн үнэлгээ, хяналтын хуудасны бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан хөтлөх, хяналт шалгалт хэрэгжүүлэх доод шатны нэгж, улсын байцаагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана. | Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн баяжуулалт (тоо) Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн тоо Хамрагдсан улсын байцаагчийн тоо | Мэдээллийн сан - 0 Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн - 5 Хамрагдсан улсын байцаагч - 60 | Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сантай болсон байна. Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн тоо - 3 Хамрагдсан улсын байцаагч - 40 | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоолоор батлагдсан "Салбарын хяналт шалгалтын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан объектыг мэдээллийн нэгдсэн сан (shilenkhyanalt.gov.mn) системд бүртгэх ажил хийгдэж байна. | 3-р сар, 4-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | Өөрийн үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 2 | Боловсролын багц хууль, түүнд нийцүүлэн гаргасан | Санал хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн тоо | Санал хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн тоо - 2 | Санал хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн тоо - 1 | Монгол Улсын Шинжлэх ухаан технологийн хууль шинэчилсэн найруулга | 6-р сар, 9-р сар | Өөрийн үнэлгээ: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дүрэм журам, стандартын хэрэгжилтийг хангуулах, дүрэм журам, стандартыг боловсронгуй болгох санал өгнө. | | | | батлах гэж байгаатай холбогдуулан шинжлэх ухааны хяналтын чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулах санал хүргүүлсэн. | | Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 3 | Их буюу дунд эрсдэлтэй үнэлэгдсэн боловсролын сургалтын байгууллагуудад төлөвлөгөөт шалгалт хийх | Шалгалт хийсэн объектын тоо Зөрчил арилгуулалтын хувь Хууль сахин мөрдөлтийн түвшин | Шалгалт хийсэн объектын тоо - 1 Зөрчил арилгуулалтын хувь - 35% Хууль сахин мөрдөлтийн түвшин - 40% | Шалгалт хийсэн объектын тоо - 1 Зөрчил арилгуулалтын хувь - 35% Хууль сахин мөрдөлтийн түвшин - 40% | Салбарын хяналтын газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Шинжлэх ухаан академийн физик технологийн хүрээлэнд 03/6.1-7 кодтой "Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас"-аар хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах улсын ахлах байцаагчдын хамтарсан хугацаатай албан шаардлага хүргүүлэн ажиллалаа. Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 2024 оны 07 дугаар сард хийж гүйцэтгэнэ.<br>Хавсралт: 1 файл | 3-р сар, 4-р сар | Өөрийн үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийх | Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь Зөрчил арилгуулалтын хувь | Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь - 90% Зөрчил арилгуулалтын хувь - 95% | Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь - 80% Зөрчил арилгуулалтын хувь - 40% | Тайлант хугацаанд нийт 7 өргөдөл, гомдол хүлээн авч, Салбарын хяналтын газрын даргын баталсан удирдамжаар төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар илэрсэн дутагдлыг арилгуулахаар улсын ахлах байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлж, биелэлтийг тооцон ажиллалаа. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилтэй холбогдуулан Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу хялбаршуулсан журмаар шийдвэрлэж 20.000 төгрөгийн торгуулийн шийтгэл ногдуулж, барагдуууллаа.<br>Хавсралт: 1 файл | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 10-р сар, 11-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 98%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 1.2. Шинжлэх ухааны чиглэлээр хууль, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, урьдчилан сэргийлэх хяналт тавих | | | | | | | |
| 5 | Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Шалгалтад хамрагдсан байгууллагын тоо Зөрчил арилгуулалтын хувь | - | Шалгалтад хамрагдсан байгууллагын тоо - 1 Зөрчил арилгуулалтын хувь - 30% | Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагаанд хийх урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг БШУ-ны сайдын 2024 оны "Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай" | 3-р сар, 4-р сар | Өөрийн үнэлгээ: 70%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 85%<br>Нэгжийн даргын |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | А/50 дугаар тушаалаар батлагдсан Дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталгаажуулах, дүгнэх ажил 3, 4, 5 дугаар сарuудад үргэлжлэн явагдсантай холбогдуулан 2024 оны 9, 10 дугаар сарuудад хийхээр төлөвлөсөн. Салбарын хяналтын газрын даргын баталсан 03-00/14 дугаартай удирдамжийн дагуу Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын хийх бэлтгэл ажлыг хангаж байна. Хавсралт: 3 файл | | үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50% |
| 6 | Шинжлэх ухаан, технологи, инновацийн үр дүнг орон нутагт түгээн дэлгэрүүлэх аяныг зохион байгуулахад оролцох | Зохион байгуулсан аяны тоо Хамрагдсан байгууллага, хүний тоо Үр дүн | Аян зохион байгуулсан аймаг - 2 | Аян зохион байгуулсан аймаг - 1 | БШУСайдын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/16 тоот тушаалын дагуу Шинжлэх ухаан, технологи, инновацийн ололт амжилтыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, орон нутагт тулгамдаж буй асуудлыг шинжлэх ухаанд тулгуурлан шийдвэрлэх соёлыг бий болгох, мэдээллийн | 3-р сар, 4-р сар, 6-р сар, 9-р сар | Өөрийн үнэлгээ: 70% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | технологийн боломжийг таниулах, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлэх чиглэлд орон нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор БШУЯ, ШУТС, аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулах “ОРОН НУТАГТ ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ, ИННОВАЦИЙГ НУТАГШУУЛЪЯ” аянд оролцохоор бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. | | гүйцэтгэсэн байдал: 50% |
| 7 | Улсын төсвийн хөрөнгөөр шинжлэх ухаан, технологийн салбарт хэрэгжиж буй судалгаа хөгжүүлэлтийн ажлын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт гаргана. | Хяналт шалгалтад хамрагдсан судалгаа хөгжүүлэлтийн ажил /тоо/ Зөрчил арилгуулалтын хувь | Хяналт шалгалтад хамрагдсан судалгаа хөгжүүлэлтийн ажил /тоо/ - 2 Зөрчил арилгуулалтын хувь - 25% | Хяналт шалгалтад хамрагдсан судалгаа хөгжүүлэлтийн ажлын тоо 1 Зөрчил арилгуулалтын хувь - 10% | Улсын төсвийн хөрөнгөөр шинжлэх ухаан технологийн салбарт хэрэгжиж буй судалгаа хөгжүүлэлтийн ажлын хэрэгжилтийн явцад урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг БШУ-ны сайдын 2024 оны "Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай" А/50 дугаар тушаалаар батлагдсан Дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталгаажуулах, дүгнэх ажил 3, 4, 5 дугаар саруудад, мөн БШУ-ны | 3-р сар, 4-р сар | Өөрийн үнэлгээ: 30%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 70%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сайдын өгсөн чиглэлийн дагуу олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх эрх бүхий ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт үргэлжлэн явагдсантай холбогдуулан 2024 оны 9, 10, 11 дүгээр саруудад хийхээр төлөвлөсөн. Хавсралт: 2 файл | | |
| 3.1. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | |
| 8 | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | ЗГХЭГ-ын даргын тушаалын дагуу тайлагнасан байна. | - | Тайлан мэдээг цаг хугацаанд нь гаргаж тайлагнасан байна. | ТАХ-ийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг4 зорилт, 12 арга хэмжээний ажил гүйцэтгэхээр төлөвлөгөө боловсруулан батлуулж, биелэлтийг ханган ажиллаж байна. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 9 | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Хөдөлмөрийн | ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд | - | Хуулийн хэрэгжилт 100% байна. | Төрийн албаны ил тод, нээлттэй, шуурхай, шударга, хариуцлагатай, | 1-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | тайлагнасан байх, хууль тогтоомжийн дагуу архивын баримт бичгийг хугацаанд нь бүрдүүлж өгсөн байна. | | | ёс зүйтэй, авлига, хүнд суртлаас ангид, ил тод шударга, хариуцлагатай, ёс зүйтэй, авлига, хүнд суртлаас ангид, ил тод шударга тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Улсын Их Хурлын Хууль зүй байнгын хорооны тогтоолын дагуу 2023 оны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд нь мэдүүлж, баталгаажуулалтын маягтыг ТЗУГ-т хүргүүлсэн. | | Нэгжийн даргын үнэлгээ: 95%<br><br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 10 | Цаг үеийн нөхцөл шаардлагаар хийж хэрэгжүүлэх ажил үйлчилгээг гүйцэтгэх | Хэрэгжүүлсэн арга хэмжээ Гүйцэтгэлийн хувь | - | Хэрэгжүүлсэн арга хэмжээ-100 Гүйцэтгэлийн хувь-100% | - БШУСайдын А/50 дугаар тушаалаар баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын 2022-2023 оны хичээлийн жилийн гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталгаажуулах, дүгнэх" ажлын хэсэгт ажилласан.<br>- Боловсрол, шинжлэх ухааны сайдын өгсөн үүрэг чиглэлийн дагуу салбарын хяналтын даргын баталсан 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 03-00/18 дугаартай удирдамжаар Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх эрх бүхий ерөнхий боловсролын 6 сургуульд төлөвлөгөөт | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br><br>Нэгжийн даргын үнэлгээ: 96%<br><br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бус хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн. - Салбарын хяналтын газраас Мэргэжлийн боловсрол, техникийн боловсролын газар, Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газар, Цахим бодлого, статистик мэдээллийн газартай хамтран газрын 2024 оны төлөвлөгөөнд тусгах санал солилцох уулзалтад оролцсон. - БШУЯ-ны 100 жилийн ойг угтаж салбарын хяналтын газраас өндөр настны тэтгэвэрт гарсан ахмад ажилтаны шагналын тодорхойлолтыг бүрдүүлж ТЗУГ-т хүргүүлсэн. - Удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу аймаг, нийслэл, дүүргийн ШТСтанцтай ойр байршилтай СӨББ, ЕБС, ЕБС-ийн дотуур байрны судалгааг нэгтгэсэн. - Удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу аймаг, нийслэл, дүүргийн БШУГ-ын судалгааг нэгтгэсэн. - Удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу БШУЯ-ны 100 жилийн ойн арга хэмжээнд оролцох үе үеийн сайд, дарга нарын нийт 15 урилгыг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүргүүлсэн. - Нэгжийн албан хаагчдын цаг бүртгэлийн тайланг ТЗУГ-т хугацаанд нь хүргүүлсэн.<br>Хавсралт: 3 файл | | |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Мэргэжил, боловсролоо дээшлүүлэх чиглэлээр танхимын болон цахим сургалтуудад хамрагдана. | Яам болон холбогдох газруудаас зохион байгуулсан цахим болон танхимын сургалтад хамрагдана. | - | Албан хаагчийн мэргэжлийн ур чадвар дээшилсэн байна. | - 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Нурагийн ерөнхий эмч С.Цэрэнпагма "Витамины хэрэглээ" болон багц оношилгооны талаарх мэдээлэлийн цагт хамрагдсан. - 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ-ийн ХАБЭА сургалт хариуцсан мэргэжилтэн Х.Дарьсүрэн "Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал"-ийн мэдээлэлийн цагт | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамрагдсан. - 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр "Ажилтны сэтгэл зүйн эрүүл мэндийн үндэс: стресс менежмент" сэдэвт мэдээлэлийн цагт хамрагдсан. - Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас зохион байгуулсан "Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан" порталыг ашиглах зааварчилгаа өгөх арга зүйгээр хангах цахим сургалтад хамрагдсан. | | |
| 2 | Төрийн албаны болон салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн шинээр болон шинэчлэн батлагдсан дүрэм журмыг уншиж судлах | Шинээр болон шинэчлэгдэн батлагдсан хууль, эрх зүйн баримт бичгүүдийг тухай бүр уншиж, судлан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ. | - | Албан хаагчийн хууль эрх зүйн мэдлэг сайжирсан байна. | Хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлж Дээд боловсролын тухай, Зөвшөөрлийн тухай Статистикийн тухай хууль, Шинжлэх ухааны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хуулийг уншиж судалж байна. | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 95% |
| 3 | Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах сургалтад хамрагдах | Худалдан авах ажиллагааны A3 гэрчилгээтэй цахим болон танхимын сургалтад хамрагдах | - | Санхүүгийн болон худалдан авах ажиллагааны талаар дээшилсэн байна. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн танилцуулга сургалтанд хамрагдсан. Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны A3 гэрчилгээ олгох шалгалтанд 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр хамрагдсан. | 3-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 80% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Салбарын хяналтын газрын ахлах мэргэжилтэн, Гунгаа Сүнжидмаа /................................................/ Огноо: .........................